СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 | IX



www.sukhbaatar.nso.mn

www.1212.mn

Баруун-Урт сум
2024 он

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024
9 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-VI, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь

▼▲ өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

мянга	=1000	$м^2$	метр квадрат
сая	$=10^6$	$км^2$	километр квадрат
тэрбум	$=10^9$	$м^3$	метр куб
см	сантиметр	мл	миллилитр
дм	дециметр	л	литр
м	метр	г	грамм
км	километр	кг	килограмм
мян.	мянга	цн	центнер
%	хувь	т	тонн
кВт.ц	киловатт цаг	ш	ширхэг
ккал	килокалори		

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 2

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6

II Хөдөлмөр 8

III Нийгмийн даатгал, халамж 11

VI Боловсрол 14

V Эрүүл мэнд 16

VI Соёл, урлаг 19

VII Газар өмчлөл 20

VII Гэмт хэрэг 21

VIII Мөнгө, банк 23

IX Арилжааны даатгал 25

X Орон нутгийн төсөв 27

XI Төсөл, хөтөлбөр 28

XII Үнэ 29

XIII Хөдөө аж ахуй 34

XIV Аж үйлдвэр 38

XV Тээвэр 42

Хавсралт хүснэгтийн жагсаалт 44

Хавсралт хүснэгтүүд 46

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	С.Мөнхбаяр
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III.а Нийгмийн даатгал	Б.Сумъяа
III.б Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Боловсрол	Ц.Азжаргал
V Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
VI Соёл, урлаг	С.Мөнхбаяр
VII Газар өмчлөл	С.Мөнхбаяр
VIII Гэмт хэрэг	Б.Сумъяа
IX Мөнгө, Банк	Ц.Азжаргал
X Арилжааны даатгал	С.Мөнхбаяр
XI Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
XII Төсөл, хөтөлбөр	Ц.Азжаргал
XIII.а Хэрэглээний үнэ	Б.Сумъяа
XIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	О.Ундрах
XIV Хөдөө аж ахуй	О.Ундрах
XV Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
XVI Тээвэр	С.Мөнхбаяр

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: С.Мөнхбаяр

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX
Төрсөн хүүхэд	хүн	809 -24.1	936 15.7	741 -20.8
Нялхасын эндэгдэл	хүн	7 40	5 -28.6	3 -40.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	352 -29.0	71 -78.8	215 3**
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	4091 -41.7	784 -80.8	507 -35.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	430 68.0	373 -13.2	369 -1.1
Хэрэгт холбогсод	хүн	304 73.7	216 -28.9	231 6.9
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	108.4 0.9	109.1 0.7	103.6 -5.0
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	131.7 -8.8	137.5 4.4	163.6 19.0
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	197.6 31.3	236.2 11.3	302.1 27.9
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	37.2 -31.5	55.7 49.6	76.2 36.8
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	34.8 -30.2	43.4 24.8	55.5 27.8
Төллөсөн хээлтэгч	тол	1 558 043 9.3	1 547 991 -0.6	550 435 -64.4
Ингэ	тол	1 397 9.6	1 278 -8.5	849 -33.6
Гүү	тол	91 748 8.8	91 431 -0.3	44 312 -51.5
Үнээ	тол	96 344 10.5	92 681 -3.8	40 610 -56.2
Эм хонь	тол	868 401 11.2	874 638 0.7	312 543 -64.3
Эм ямаа	тол	500 153 6.1	487 963 -2.4	152 121 -68.8
Бойжуулсан төл	тол	1 547 821 9.5	1 119 340 -27.7	443 166 -60.4
Ботго	тол	1 385 10.0	1 217 -12.1	797 -34.5
Унага	тол	91 186 8.9	74 116 -19.4	41 565 -43.9
Тугал	тол	95 702 10.6	77 171 -19.4	38 107 -50.6
Хурга	тол	864 066 11.3	631 744 -26.9	246 990 -60.9
Ишиг	тол	495 482 6.6	335 092 -32.4	115 702 -65.5
Том малын зүй бусын хорогдол	тол	13 371 -68.8	566 519 42.4**	1 820 118 3.2**
Тэмээ	тол	33 -10.8	97 2.9**	309 3.2**
Адуу	тол	1 476 -25.9	26 781 18.1**	72 382 2.7**
Үхэр	тол	1 526 -65.3	29 679 19.4**	135 451 4.6**
Хонь	тол	4 900 -71.1	266 221 54.3**	1 063 638 4.0**
Ямаа	тол	5 436 -72.2	243 741 44.9**	548 338 2.3**
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	210 42.0**	83 -60.5	83
Үхэр	тол	89 6.4**	-	20
Хонь	тол	56	83 48.2	54 -34.9
Ямаа	тол	65	-	9
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	120.2 9.5	162.4 35.1	197.5 21.6
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	270.6 54.5	353.1 30.5	285.1 -19.2

Тайлбар: ** дахин


ХҮН АМ, жил бүрийн эхний 9 сард
Амаржсан эх
735
Төрсөн хүүхэд
741
1 000 хүнд ногдох
Ердийн цэвэр өсөлт
8.7
10.7
7.3
2022 I-IX
2023 I-IX
2024 I-IX
Төрөлт
12.3
14.2
11.2
2022 I-IX
2023 I-IX
2024 I-IX
Нас баралт
3.6
3.4
3.9
2022 I-IX
2023 I-IX
2024 I-IX

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 20.8 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2024 оны эхний 9 сард 735 эх амаржиж, 741 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 197(21.1%)-аар, төрсөн хүүхэд 195(20.8%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 9 сард



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 3.0 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 9 сард

2024 оны эхний 9 сард нас баралт 257 болж, өмнөх оноос 30(13.2%)-аар өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 11.2, нас баралт 3.9, ердийн цэвэр өсөлт 7.3 байна.
1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.5 нэгжээр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2024 оны 9 дүгээр сар

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, насны бүлгээр, тоогоор

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 2.9 хувиар өслөө.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2024 оны 9 дүгээр сарын эцэст 215 болсны 67 (31.2%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 144 (3.0 дахин) хүнээр өсч, 2023 оны 12 дугаар сарын эцсээс 87 (28.8%) хүнээр буурсан байна.
Эхний 9 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1155 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 479 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 157 (73.0%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1(0.5%)нь магистр, доктор, 35 (16.3%) нь дээд, бакалавр, 4 (1.9%) нь тусгай мэргэжлийн дунд, 11(5.1%) нь техник болон мэргэжлийн анхан шатны боловсролтой, 84 (39.1%) нь бүрэн дунд, 50 (23.3%) нь суурь, 23 (10.7%) нь бага, 7 (3.3%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 9 сарын байдлаар

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

НИЙГМИЙН ДААТГАЛ, 2024 оны эхний 9 сард

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг



* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

Албан журмаар даатгуулагчид

Сайн дураар даатгуулагчид

ТЭТГЭВЭРАВАГЧИД 10 024

Өндөр насны тэтгэвэр 7 929

Тахир дутуугийн тэтгэвэр 1 324

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 374

Цэргийн тэтгэвэр 372

Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр 25

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 11.9 (24.4%) тэрбум төгрөгөөр өслөө.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 1.4 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.2% -р буурсан байна.

2024 оны 9-р сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 10.0 мянган иргэнд 60.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.9 мянган өндөр настанд 48.2 тэрбум төгрөг, 1.3 мянган тахир дутуу иргэнд 6.2 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 1.8 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 4.5 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.03 мянган иргэнд 0.2 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна. Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 311 (3.2%) хүнээр өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2024 оны эхний 9 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1516 хүн хамрагдсан нь өмнөх оноос 59(4.0%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 4.6 тэрбум төгрөг болж 935.4(25.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2024 оны эхний 9 сарын байдлаар 2807 хүн хамрагдсаны 50.6 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.4 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 4.1 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 1.9 (86.5%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, эхний 9 сар

Үзүүлэлт	2022 I-IX		2023 I-IX		2024 I-IX	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**25 626**	**8 402.9**	**25 040**	**9 573.6**	**26 325**	**12 307.4**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	6 824	5 140.7	5 000	6 036.3	5 025	8 848.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 340	3 282.7	1 457	3 660.0	1 516	4 595.4
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 213	1 570.6	2 422	2 224.1	2 807	4 148.8
Нийгмийн халамжийн үйлчилгээ	172	60.3	159	69.8	17	34.0
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	3 099	227.1	962	82.4	685	70.7
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 659	735.7	5 795	747.7	5 967	759.9
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 669	224.6	5 225	407.6	6 142	325.3
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	5	1.4	7	0.8	10	1.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	326	66.1	389	104.3	561	146.4
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 312	1 787.3	5 375	1 777.0	4 929	1 688.0
Насны хишиг	2 836	448.5	3 249	500.0	3 691	537.0

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 685 хүн хамрагдсан нь өмнөх оноос 277(28.8%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр халамж үйлчигээний газрын халамжийн сарын мэдээ

2024-2025 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо өмнөх оноос 263-өөр өслөө.

Ерөнхий боловсролын сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 14.5 мянган суралцагчид байгаагийн 7.3 (50.1%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 263 (1.8%) хүүхдээр өсчээ.

Нийт суралцагчдын 7.1 (49.0%) мянга нь 1-5-р ангид, 5.2 (35.6%) мянга нь 6-9-р ангид, 2.2 (15.4%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.4 мянган суралцагчид элсэн орсны 678 (47.7%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 9 (1.3%) суралцагчаар буурсан байна. Мөн 12-р ангид 661 суралцагчид байгаагийн 409 (61.9%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 67 (2.5%) суралцагчаар буурсан байна.

Энэ хичээлийн жилд 476 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30.4 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Нийт ажиллагсдын 668 (56.3%) үндсэн багш байна. Үүний 548 (82.0%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 14 (2.1%) багшаар буурсан байна.

Дотуур байранд 1048 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 42 (3.9%) сурагчаар буурчээ.

ЗУРАГ 5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТОО



Сургуулийн өмнөх боловсрол 2024-2025 оны хичээлийн жилд 166 бүлэгт 5.5 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.7 (49.3%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 122 (2.2%) хүүхдээр буурчээ.

2024-2025 оны хичээлийн жилд СӨБ-д 681 ажиллагсад байгаагийн 192 (28.2%) нь үндсэн багш, 148 (21.7%) нь туслах багш байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндсэн багшийн тоо 4 (2.1%)-р өссөн, туслах багш мөн үетэй ижил түвшинд байна. Нийт үндсэн багш нарын 8 (4.2%), туслах багш нарын 3 (2.0%) нь эрэгтэй багш байна.

ЗУРАГ 6. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2024-2025 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 13 мэргэжлээр 405 суралцагчид суралцаж байгаагийн 145 (35.8%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 9 (2.2%) суралцагчаар буурсан байна.

Нийт суралцагчдын 99 (24.4%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 70 (17.3%) барилга бүтэц, угсралт, 53 (13.1%) цахилгаан хангамж. тоног төхөөрөмж ашиглалт, 52 (12.8%) механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар, үйлчилгээ, 44 (10.9%) хоолны үйлчилгээ, 38 (9.4%) үс засал, гоо сайхны үйлчилгээ, 30 (7.4%) оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 28 (6.9%) гагнуурчин, 21 (5.2%) барилгын сантехник, хоолой угсралт гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Эх үүсвэр: Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн улирлын мэдээ.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 9 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

2023 I-IX **12 039**

2024 I-IX **13 416**

11.4%

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

2023 I-IX **784**

2024 I-IX **507**

35.3%

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2023 I-IX **4**

2024 I-IX **6**

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2023 I-IX **5**

2024 I-IX **3**

2024 оны эхний 9 сарын байдлаар эхийн эндэгдэл 1 гарчээ.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2024 оны эхний 9 сард 735 эх амаржсан нь өмнөх оноос 197(21.1%)-аар буурсан байна. Нийт амаржсан эхийн 0.3 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 673(91.6%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 26(3.5%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, эхний 9 сард

Үзүүлэлт	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2024 I-IX / 2023 I-IX
	тоо			хувь
Амаржсан эх	811	932	735	78.9
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	762	903	692	76.6
Гэрийн төрөлт	2	4	2	50.0
Амьд төрсөн хүүхэд	809	936	741	79.2
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	735	890	673	75.6
төрөлхийн гажигтай төрсөн	5	6	8	133.3
2500 граммаас доош жинтэй төрсөн	26	31	26	83.9
Амьгүй төрсөн хүүхэд	4	4	-	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	4.9	4.3	-	-

2024 оны эхний 9 сард нас баралтын 257 тохиолдол бүртгэгдсэний 38(14.8%) нь осол гэмтлийн улмаас, 74(28.8%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 6 сард

Үзүүлэлт	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2024 I-IX / 2023 I-IX
	тоо			хувь
Нас баралт	236	227	257	113.2
Эмнэлгийн нас баралт	49	40	54	135.0
Эхийн эндэгдэл	1	-	1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	27	46	38	82.6
Хорт хавдрын өвчлөл нас баралт	71	57	74	129.8
0-1 насны эндэгдэл	7	4	6	150.0
1-5 хүртэлх насны эндэгдэл	4	5	3	60.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2024 оны эхний 9 сард 507 болж, өмнөх оны мөн үеэс 277(35.3%)-аар буурахад короновируст халдварын тохиолдол болон салхинцэцэг өвчины өвчлөл буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 9 сар

Халдварт өвчин	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	Өсөлт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**4 091**	**784**	**507**	**- 277**	**64.7**
Вируст гепатит	3	3	1	- 2	33.3
Цусан суулга	16	25	13	- 12	52.0
Гахайн хавдар	-	2	1	- 1	50.0
Бруцеллёз	2	-	1	1	-
Салхинцэцэг	13	202	132	- 70	65.3
Энтервируст халдвар	-	104	83	- 21	79.8
Улаан эсэргэнэ	-	13	-	- 13	-
Ecoli-оор/ A04.4/	-	-	14	14	-
Ёлом	-	1	-	- 1	-
Салмонеллт	-	19	23	4	121.1
Гар хөл амны өвчин	33	119	84	- 35	70.6
Тархины феомикоз буглаа	-	-	1	1	-
Хачигт	-	4	1	- 3	25.0
Сүрьеэ	50	46	44	- 2	95.7
Тэмбүү	40	24	29	5	120.8
Заг	47	38	52	14	136.8
Трихомониаз	68	43	28	- 15	65.1
Ковид-19	3 819	141	-	- 141	-

Салхин цэцгээр өвчлөгчид 70(34.7%)-аар, гар хөл амны өвчин 35(29.4%)-аар буурч, шинээр Ecoli-оор/A04.4/ өвчины 14, Тархины феомикоз буглаа 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 203.3 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 0.4(0.2%) мянган хүнээр буурч, 13.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 41.5 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 6.6(13.7%) мянган хүнээр буурсан.

Түргэн тусламжийн дуудлага 12.2 мянган удаа гарсны 2.4(19.7%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 46(1.9%) удаагийн дуудлагаар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын сарын мэдээлэл

Соёл, урлаг

Хөгжимд жүжгийн театр: 2024 оны эхний 9 сард 14.5 мянган үзэгчдэд 24 удаа тоглолтоор үйлчилж, 74.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 17(41.5%)-аар буурч, танхимын үзэгчдийн тоо 0.6 мянгаар буюу 4.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 7. НИЙТ ТОГЛОЛТЫН ТОО



ЗУРАГ 8. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Музей: 2024 оны эхний 9 сард 4.1 мянган хүнд 2.5 мянган үзмэрээр үйлчилж, 2.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо 135(5.6%)-оор нэмэгджээ.

ЗУРАГ 9. НИЙТ ҮЗМЭРИЙН ТОО



ЗУРАГ 10. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Номын сан: 2024 оны эхний 9 сард 50.5 мянган номоор 7.9 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.4(0.8%) мянгаар өсч, уншигчдын тоо 20.1(71.8%) мянган хүнээр өсчээ.

ЗУРАГ 11. НИЙТ НОМЫН ТОО



ЗУРАГ 12. НИЙТ УНШИГЧДЫН ТОО, мян.хүн



Эх үүсвэр: Жаахан шарга хөгжим жүжгийн театр, Усгаатны зүйн музей, Нийтийн номын сангийн улирлын мэдээ.

2024 онд шинээр 22 иргэнд газар олгожээ.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 12.7 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 11.9 мянган иргэнд 1121.39 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

ЗУРАГ 13. ГАЗАР ӨМЧЛӨХ ӨРГӨДӨЛ ГАРГАСАН ИРГЭДИЙН ТОО, сумаар



ЗУРАГ 14. ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭР ГАРГАСАН ИРГЭДИЙН ТОО, сумаар



ГЭМТ ХЭРЭГ, 2024 оны эхний 9 дүгээр сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2023 I-IX	2024 I-IX	
373	369	1.1% ↓

Хөнгөн хэрэг
279

Хүнд хэрэг
90

Илрүүлэлтийн хувь
50.3%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
128

Нас барсан хүн
11

Хохирол сая төг
1158.5

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
14

Согтуугаар
155

Ял шийтгэгдэж байсан
56

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 4 (1.1%)-өөр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 128 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1 158.5 сая төгрөгийн хохирол учирсны 31.9 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 231 хүн холбогдон сэжиглэгдсэний 155 (67.1%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.

2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 286 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхээр 151 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 50.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.8 нэгжээр өссөн байна.

Зураг 15. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2024 оны 9 сард

Нийт зээлдэгчийн тоо

2023 IX 35 090

2024 IX 37 648

Зээл 2024 IX

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 302.1 тэрбум төгрөг

Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл 1.6 тэрбум төгрөг

Чанаргүй зээл 1.5 тэрбум төгрөг

ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ 2024 IX

Нийт 163.6 тэрбум төгрөг

Хугацаатай 142.8 тэрбум төгрөг

Хугацаагүй 20.8 тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо 35

АТМ-ны тоо 34

Ажилтнуудын тоо 183

Карт эзэмшигчийн тоо 58 288

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 9 сарын байдлаар 1.5 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 302.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 3.5 (1.2%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 65.9 (21.8%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 163.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.0 (1.2%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 26.1 (16.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн 87.3% нь хугацаатай, 12.7 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 16. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

ДААТГАЛ, 2024 оны эхний 9 сард, мянган төгрөг

Сайн дурын даатгал	Хураамжийн орлого	Нөхөн төлбөр
Гэнэтийн осол, эмчилгээний	52 181.3	25 801.0
Хөрөнгийн	868.0	-
Авто тээврийн хэрэгслийн	288 125.9	52 323.3
Ачаа хүргэлт	-	-
Барилга угсралтын	-	-
Мал амьтдын	119 716.2	217 271.4
Агаарын хөлгийн	-	-
Зээлийн	61 432.8	-
Бусад	157 508.8	8 939.0
Албан журмын даатгал		
Жолоочийн хариуцлагын	375 753.4	105 170.5

Даатгалын нөхөн төлбөр өмнөх оноос 86.1 хувиар өсчээ.

Даатгалын хураамжийн орлого 2024 оны эхний 9 сард 1081.3 сая төгрөг хүрч өмнөх оноос 69.6(6.9%) сая төгрөгөөр өсч, даатгалын нөхөн төлбөрт 409.5 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 189.5(86.1%) сая төгрөгөөр өссөн байна.

Даатгалын хураамжийн 65.3 хувийг сайн дурын даатгал, 34.7 хувийг албан журмын даатгал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний сард

Үзүүлэлт	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2024 I-IX / 2023 I-IX
	сая төгрөг			хувь
Хураамжийн орлого	1 056.6	1 011.7	1 081.3	106.9
Нөхөн төлбөр	224.3	220.0	409.5	186.1
Даатгуулагчдын тоо	37 297	28 081	22 729	80.9

Даатгалын хураамжийн нийт орлогын 375.8(34.8%)-ийг жолоочийн хариуцлагын даатгал, 288.1(26.6)-ийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 61.4(5.7%)-ийг зээлийн эрсдлийн даатгал, 119.7(11.1%) малын индексжүүлсэн даатгал эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн 25.7 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 12.8 хувийг тээврийн хэрэгслийн даатгал, 6.3 хувийг гэнэтийн осолын даатгал, 1.1 хувийг хурдан морь унаач хүүхдийн даатгал, 53.1 хувийг малын индекжүүлсэн даатгал, 1.0 хувийг хөдөлмөрийн чадвараа түр алдсны даатгал тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдолд үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажилаагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.

Эх үүсвэр: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны даатгалуудын улирлын мэдээлэл

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 36.8 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2024 оны эхний 9 сарын байдлаар 76.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20.5(36.8%) тэрбум төгрөгөөр өсч, төсвийн зарлага санхүүжилт 55.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 120.9(27.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 17. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 36.0 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.9 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 10.1 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 16.4 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 21.5 хувийг урьд оны үлдэгдэл, 2.9 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар аймгийн нийт хөрөнгө оруулалт 5.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.8(99.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

Аймгийн хэмжээнд малжуулах хөтөлбөрт 341 өрхийг 14.3 мянган толгой мал 2.7 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлжээ.

Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 42 иргэнд 404.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд 13 төслийн хүрээнд 1.2 мянган иргэнд 283.5 сая, мод тарих арга хэмжээнд 36 иргэнд 13.7 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 26 иргэнд 152.0 сая, залуучуудын гарааны бизнес санхүүгийн дэмжлэгт 1 иргэнд 10.0 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 25 иргэнд 146.0 сая, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 341 өрхөд 2.7 тэрбум төгрөгөөр 14.3 мянган толгой малыг тус тус олгоод байна.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчигээний газрын халамжийн мэдээг авч нэгтгэн оруулдаг.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2024 оны 9 дүгээр сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 9 дүгээр сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 5.7 хувь, өмнөх оны эцсээс 3.6 хувь, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 18. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 7.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 19.2 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсээс 3.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 6.7 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 19.2 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 6. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2024 оны 9 дүгээр сард

Бараа үйлчилгээний бүлэг	2024 IX / 2023 IX	2024 IX / 2023 XII	2024 IX / 2024 VIII
Ерөнхий индекс	**105.7**	**103.6**	**100.2**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	107.7	104.0	98.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	99.3	97.6	96.9
Хувцас, бөс бараа, гутал	112.1	108.0	104.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.4	102.1	99.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	107.1	106.7	100.8
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	104.5	102.6	100.2
Тээвэр	98.6	97.0	99.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	103.6	103.6	100.6
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	119.2	119.2	100.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	109.6	109.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.3	103.2	100.4

ЗУРАГ 19. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2024 оны 9 дүгээр сард өмнөх сараас хонь, ямааны махны үнэ дунджаар 0.4 хувь, адууны махны үнэ дундажаар 2.5 хувь, тахианы махны үнэ дундажаар 0.9 хувиар тус тус буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.6 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2024 оны 09 дүгээр сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.0 сая төгрөг болж, 229.2 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 987.5 мянган төгрөг болж, 97.0 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.6 сая төгрөг болж, 25.6 мянган төгрөгөөр, тус тус буурсан бол эр ямааны үнэ 152.5 мянган төгрөг болж, 10.7 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 236.9 мянган төгрөг болж, 18.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 20. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, 9 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2024 оны 09 дүгээр сард Дарьганга суманд хамгийн их буюу 2.5 сая төгрөг, Баяндэлгэр, Онгон сумдад хамгийн бага буюу 1.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 21. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2024 оны 9 сард, мянган төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ 2024 оны эхний 9 сард



Мал төллөлт аймгийн хэмжээнд 29.6 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар оны эхний төллөх насны 1859.6 мянган хэлтэгч малын 0.6 сая (29.6%) нь төллөжээ. Гүүний 34.8 хувь, үнээний 31.9 хувь, ингэний 28.2 хувь, эм хонины 30.4 хувь, эм ямааны 26.5 хувь нь төллөсөн байна.

ЗУРАГ 22. ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, мянган толгой



Бойжуулсан төл 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 0.4 сая болж, бойжилтын хувь 80.5 хувь байна. Гарсан унаганы 93.4 хувь, тугалын 93.8 хувь, ботгоны 93.2 хувь, хурганы 79.0 хувь, ишигний 76.0 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 108.0 мянган толгой төл мал хорогдсоноос унага 2.7 мянган толгой, тугал 2.5 мянган толгой, ботго 52 толгой, хурга 65.9 мянган толгой, ишиг 36.7 мянган толгой төл мал хорогдоод байна.

Оны эхний малын 47.2 хувь буюу 1.8 сая толгой том мал 2024 оны эхний сарын байдлаар зүй бусаар хорогдлоо.

ЗУРАГ 23. ХОРОГДСОН МАЛЫН ТОО, сумаар, мянган толгой



Хорогдолыг малын төрлөөр авч үзвэл 72.4 мянган толгой адуу, 135.5 мянган толгой үхэр, 309 толгой тэмээ, 1063.6 мянган толгой хонь, 548.3 мянган толгой ямаа байна. Нийт хорогдсон малын 1820.0 мянга (99.9%) нь аюулт үзэгдлээр хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Үр тариа 3.9 мянган га-д тариалалт хийсэн байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар төмс 64.7 га, хүнсний ногоо 47.9 га, үр тариа 3.9 мянган га, тэжээлийн ургамал 2.2 мянган га, техникийн ургамал 3.2 мянган га-д тариалсан байна.

Үр тариа 3.9 мянган га тариалсанаас 2.8 мянган га улаан буудай, 0.3 мянган га арвай, 0.8 мянган га овьёос тариалсан байна.

ЗУРАГ 24. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад техникийн ургамал 1.3 мянган (1.7 дахин) га-аар, тэжээлийн ургамал 0.9 мянган (1.8 дахин) га-аар тус тус өссөн бол төмс 26.5 (29.1 %) га-аар, хүнсний ногоо 20.3 (29.8%) га-аар, үр тариа 282.0 (6.8%) га-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 25. ХУРААСАН УРГАЦ, тн



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 182.3 тн-оор буюу 54.3 хувиар, хүнсний ногоо 182.0 тн-оор буюу 48.1 хувиар тус тус өссөн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 9 дүгээр сар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг

Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 17.7 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 197.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 35.1 (21.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 33.9 (26.6%) тэрбум төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 2.9 (28.1%) тэрбум төгрөг, усан хангамж, хог хаягдал зайлуулах, сэргээх үйл ажиллагаа 0.6 (48.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 26. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



